



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2023 оны 02 сарын 28 өдөр

Дугаар А/71

Улаанбаатар хот

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн
дүрэм, бүтцийг батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх заалт, 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 149 дүгээр тогтоол, 2021 оны 144 дүгээр тогтоолыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн дүрмийг нэгдүгээр, зохион байгуулалтын бүтцийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв шинэчлэгдэн байгуулагдсан дүрэм, бүтцийн дагуу зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал /С.Өнөрсайхан/-д үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн 2017 оны А/33 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



САЙД

S. Chinzorig

С.ЧИНЗОРИГ

141223339

Эрүүл мэндийн сайдын 2023 оны
02 сарын 28-ны өдрийн 171 дугаар
тушаалын 1 дүгээр хавсралт



НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв (цаашид "төв" гэх) нь нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх эрдэм шинжилгээ, судалгаа, сургалт, үйлдвэрлэл эрхэлдэг эрдэм шинжилгээний байгууллага мөн.

1.2. Төв нь хүн амын эрүүл мэндийн байдал, өвчлөлд хүргэх эрсдэлт хүчин зүйлс, өвчнийг үүсгэж буй шалтгаан, үр дагаврыг судлах, тандах, үнэлэх, хянах, хариу арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах, биотехнологи, инновацийг хөгжүүлэх, хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх аливаа зүйлд өртөхөөс хамгаалах, урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийг дэмжих ажлыг тэгш, хүртээмжтэй улсын хэмжээнд чадварлаг, олон талт мэргэжилтнүүдийг бүрдүүлэн гүйцэтгэнэ.

1.3. Төв нь төрийн өмчит хуулийн этгээд байна.

1.4. Төв нь эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шууд удирдлагад харьяалагдан ажиллана.

1.5. Төв нь Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл ахуйн тухай хууль, Шинжлэх ухаан технологийн тухай хууль, Хүнсний тухай хууль, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай хууль, Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай, баяжуулсан хүнсний тухай, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа явуулна.

1.6. Төв нь Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн баримт бичгүүд, эрүүл мэндийн салбарын урт, дунд, богино хугацааны баримт бичгүүдтэй нийцүүлэн баталсан стратеги төлөвлөгөөтэй байна.

1.7. Төвийн албан ёсны хаяг нь Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 3-р хороо, Энхтайваны өргөн чөлөө, гудамж-17. Холбоо барих утас: 11458645. цахим хуудасны хаяг: www.ncph.gov.mn, цахим шуудангийн хаяг: info@ncph.gov.mn байна.

1.8. Төвийн нэрийг англи хэл дээр "National Center for Public Health" гэж орчуулна.

1.9. Төв нь холбогдох хууль тогтоомжийн дагуу үйлдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас, санхүүгийн харилцах данстай байна.

1.10. Төв нь байгууллагын дотоод журамтай байна.

Хоёр. Үндсэн зорилго, чиг үүрэг

2.1. Алсын хараа

2.1.1. "Эрүүл нийгэмд Эрүүл хүн ам"

2.2. Эрхэм зорилго

2.2.2. Хувь хүн, гэр бүл, хамт олон, төрийн болон төрийн бус байгууллагын салбар дундын оролцоонд тулгуурласан нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үндэсний түвшинд үзүүлж, чанар, хүртээмжийг сайжруулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг эрхлэн, нотолгоонд суурилсан нийгмийн эрүүл мэндийн бодлогыг хэрэгжүүлэхэд оршино.

2.3. Үйл ажиллагааны үндсэн чиглэл

2.3.1. Монгол Улсын болон Эрүүл мэндийн салбарын урт, дунд, богино хугацааны бодлогод туссан нийгмийн эрүүл мэндийн зорилго, зорилт, арга хэмжээг үндэсний түвшинд хэрэгжүүлэхэд эрүүл мэндийн байгууллагыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах;

2.3.2. Нийгмийн эрүүл мэндийг дэмжих олон талт, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

2.3.3. Хүний эрүүл мэндэд нөлөөлж буй нийгэм, зан үйл, хоол, хүнс, хүрээлэн буй орчны эрсдэлт хүчин зүйлсийг тогтоох, үнэлэх, судлах, тандах, хянах, судалгааны үр дүнг нийтэд болон холбогдох байгууллага, шийдвэр гаргагчдыг мэдээллээр хангах, практикт нэвтрүүлэхэд мэргэшил арга зүйн дэмжлэг үзүүлэх;

2.3.4. Төрөөс шинжлэх ухаан технологийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд оролцох;

2.3.5. Хүн амд өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх, өөрийгөө хамгаалах, эрүүл мэндээ дэмжих үр дүнтэй мэдээлэл харилцааг зохион байгуулж эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, эрт илрүүлгийн арга хэмжээг нэгдсэн зохион байгуулалтаар хангах, мэдээлэх, хянах, салбарын болон салбар хоорондын уялдаа, байгууллагуудын оролцоог хангах;

2.3.6. Бусад салбарын бодлого, үйл ажиллагаанаас хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг үр дагаврыг бууруулах ажлыг зохион байгуулах, эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ хийх, лавлагаа зөвлөмжөөр хангах;

2.3.7. Эрүүл зүйн лавлагаа лабораторийг хариуцан ажиллах;

2.3.8. Биотехнологи, биоинновацийг хөгжүүлэх, вакцин, биобэлдмэлийг турших, үйлдвэрлэх, нийлүүлэх.

2.4. Үйл ажиллагааны зарчим

2.4.1. Нийтэч, ил тод, санаачилгатай: Үйл ажиллагаандаа нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, эрдэм шинжилгээний байгууллагын нийтлэг үнэт зүйлсийг эрхэмлэж, ажилтан бүр шинэ техник, технологи, инновацийг нэвтрүүлэгч, санаачлагч, суралцагч, бүтээлч байна.

2.4.2. Эвсэг, эерэг, ёс зүйтэй: Нийгмийн өмнө хүлээсэн төрийн албан хаагчийн үүрэг, хариуцлагаа дээдлэн, ёс зүй, эерэг харилцаа хандлагыг эрхэмлэн, манлайлж ажиллана.

2.4.3. Мэргэшсэн, мэдлэг чадвартай: Ажил үүргээ мэргэжлийн түвшинд мэдлэг, чадварт тулгуурлан гүйцэтгэж, үр дүнг эрхэмлэн ажиллана.

2.4.4. Үнэнч, шударга, хариуцлагатай: Алхам бүрд хууль тогтоомжийг мөрдөж, шударга, ил тод, шуурхай ажиллана.

2.4.5. Тэгш, хүртээмжтэй: Ялгаварлан гадуурхалтаас ангид байж, тэгш, хүртээмжтэй байдлыг хангаж ажиллана.

Гурав. Удирдлага, зохион байгуулалт

3.1. Төвийн гүйцэтгэх удирдлагыг Захирал хэрэгжүүлнэ.

3.1.1. Бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга захирлын эзгүйд түүнийг орлоно.

3.1.2. Төвийн Захирлын дэргэд байгууллагын үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх, шийдвэр гаргахад туслан зөвлөх үүрэг бүхий Захирлын зөвлөл ажиллана.

3.1.3. Захирлын зөвлөлийн бүрэлдэхүүнийг Захирлын тушаалаар батална.

3.1.4. Захирлын зөвлөлийн хурлаас зөвлөлийн шийдвэр бүхий хурлын тэмдэглэл гарна.

3.2. Төвийн дэргэд Эрдмийн зөвлөл ажиллана.

3.2.1. Эрдмийн зөвлөл нь судалгаа, шинжилгээний ажлын хэтийн болон ойрын зорилт, тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, эрдэм шинжилгээ судалгааны эрүүл мэндийн технологийн үнэлгээний сэдэв, аргачлалыг батлах, явц, үр дүн, тайланг хэлэлцэх, сургалт, эрдэм шинжилгээ, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний асуудлаар үнэлэлт, санал зөвлөмж өгөх үүрэгтэй.

3.2.2. Эрдмийн зөвлөлийн дүрэм, бүрэлдэхүүнийг Захирал батална.

3.2.3. Эрдмийн зөвлөлийн дарга төвийн Захирал, нарийн бичгийн дарга нь төвийн Эрдэм шинжилгээ, судалгааны хэлтсийн дарга байна.

3.2.4. Эрдмийн зөвлөл нь шинжлэх ухаан, боловсролын докторын зэрэг бүхий 15-аас дээш хүний бүрэлдэхүүнтэй байна.

3.3. Төв нь ажилтнуудын хөдөлмөрлөх эрх ашгийг хамгаалах, ажиллах нөхцөл болон нийгмийн хамгааллыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх үндсэн зорилго бүхий "Үйлдвэрчний эвлэл"-тэй байж болно.

3.4. Төв нь дэргэдээ салбар хороод болон зөвлөлийг хууль, тогтоомжийн хүрээнд байгуулан ажиллуулна.

Дөрөв. Санхүүжилт

4.1. Төвийн санхүүжилт нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:

4.1.1. Улсын төсөв;

4.1.2. Эрүүл мэндийг дэмжих сан;

4.1.3. Хууль тогтоомжоор зөвшөөрсөн үйл ажиллагааны орлого;

4.1.4. Төсвийн тухай хуульд заасан журмын дагуу Монгол Улсын болон гадаадын иргэн, хуулийн этгээд, хувь хүнээс авсан хандив, тусламж;

4.1.5. Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн санхүүжилт;

4.1.6. Хууль, тогтоомжид заасан бусад эх үүсвэр.

4.2. Төв нь хууль, тогтоомжийн дагуу төсвийг зарцуулан бүртгэж тайлагнана.

Тав. Гадаад, дотоод хамтын ажиллагаа

5.1 Төвийг гадаад, дотоодын үйл ажиллагаанд Захирал төлөөлнө.

5.2 Төвийн Захирлын гадаад оронд туршлага судлах, мэргэжлийн сургалтад суралцах, хурал, семинарт оролцох албан томилолтыг Эрүүл мэндийн сайдын тушаалаар шийдвэрлэнэ.

5.3 Төвийн ажилтны гадаад, дотоодод албан томилолтоор ажиллах, мэргэжлийн сургалтад суралцах, хурал, семинарт оролцох албан томилолтыг Захирал шийдвэрлэнэ.

5.4 Төв нь эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын захирал, газрын дарга нартай шууд харилцаж, эрүүл мэндийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг биелүүлэх ажлыг зохион байгуулахдаа чиглэл, үүрэг, зөвлөмж авч үйл ажиллагаагаа уялдуулан ажиллана.

5.5 Төв нь аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дэргэдэх Нийгмийн эрүүл мэндийн төв, Эрүүл мэндийг дэмжих төвүүдийг мэргэжлийн удирдлага арга зүйгээр хангаж, үндэсний хэмжээнд нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлнэ.

5.6 Төв нь өөрийн эрхлэх асуудлаар бусад эрүүл мэндийн байгууллага, төрийн ба төрийн бус байгууллага, аж ахуй нэгж, иргэдтэй шууд харилцана.

5.7 Хууль, журмын хүрээнд байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүнтэй ажил үйлчилгээ гүйцэтгэх гэрээ, хэлцэл байгуулан баталгаажуулахыг төвийн Захирал хэрэгжүүлнэ.

5.8 Албан тушаалтан хандив, санхүүгийн туслалцааг авахын өмнө өөрийн удирдлага, эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авсан байна.

Зургаа. Эрх, үүрэг

6.1. Төв дор дурдсан эрхтэй

6.1.1. Өөрийн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн эрх зүйн баримт бичиг боловсруулан, мөрдүүлэх, шаардагдах бүтэц, нөөц, төсвийг бүрдүүлж, хууль, тогтоомж, дүрэм, журмын дагуу захиран зарцуулах;

6.1.2. Ижил чиг үүрэг бүхий гадаад улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэн, байгууллагыг хөгжүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах чиглэлээр хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, харилцан туршлага солилцох;

6.1.3. Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх, санал, зөвлөмж өгөх;

6.1.4. Үндэсний болон олон улсын эрдэм шинжилгээний хурал, сургалт, семинар зохион байгуулах, оролцох;

6.1.5. Дотоод, гадаадын төрийн, төрийн бус, хувийн хэвшлийн байгууллага, иргэдтэй хамтран ажиллах, шаардлагатай тохиолдолд харилцан ойлголцлын санамж бичиг, гэрээ байгуулах;

6.1.6. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүргэхэд шаардлагатай хүний нөөц, санхүүжилт, хөрөнгө оруулалтын асуудлаар төрийн захиргааны төв байгууллагад нотолгоонд суурилсан санал боловсруулан уламжилж, шийдвэрлүүлэх;

6.1.7. Байгууллагын талаар болон нийгмийн эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгааны чиглэлээр цахим хуудас, мэдээний сан зэргийг үүсгэх;

6.1.8. Хүн амд зориулсан нийгмийн эрүүл мэндийн мэдээлэл, сурталчилгааны болон байгууллагаас хийсэн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын тайлан, үр дүнг хэвлэх зорилгоор ном, гарын авлага, сэтгүүл эмхэтгэл зэргийг эрхлэн гаргах, түгээх;

6.2 Төв нь дор дурдсан үүрэгтэй

6.2.1. Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл ахуйн тухай хууль, Шинжлэх ухаан, технологийн тухай хуулиуд, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого, Төрөөс шинжлэх ухааны талаар баримтлах бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, салбарын стратеги төлөвлөгөө, Эрүүл мэндийн яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан хамаарах зорилт, арга хэмжээ болон холбогдох үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах;

6.2.2. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, эрсдэлийн удирдлагыг хангах хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх;

6.2.3. Байгууллагын үндсэн чиг үүрэг, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх арга хэмжээний саналыг боловсруулан төрийн захиргааны төв байгууллагад танилцуулах;

6.2.4. Нийгмийн эрүүл мэндийн чиглэлийн нотолгоо бүхий мэдээллээр хангах;

6.2.5. Эрүүл мэндийн байгууллагуудад нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг явуулахад шаардлагатай стандарт, удирдамж, аргачлал боловсруулах, хэрэгжилтэд мэргэшлийн арга зүйгээр хангах;

6.2.6. Хүн амд хүргэх нийгмийн эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгааг үндэсний хэмжээнд зохион байгуулах, бусад байгууллагаас зохион байгуулж байгаа нийгмийн эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгааны агуулгад хяналт тавих, заавар, зөвлөгөө өгөх,

6.2.7. Өөрийн үйлдвэрлэсэн вакцин, биобэлдмэлийг хүлээн зөвшөөрөгдсөн арга аргачлалын дагуу турших, хянах, үйлдвэрлэх, нийлүүлэх, нөөц бүрдүүлэх;

6.2.8. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын шалгуурыг ханган ажиллах;

6.2.9. Төвийн ажилчид, үйлчлүүлэгчид, хамтран ажиллагчдын санал, хүсэлт, гомдлыг шуурхай хүлээн авч шийдвэрлэх тогтолцоог бүрдүүлэх, санал гомдолд дүн шинжилгээ хийж, залруулах арга хэмжээг үйл ажиллагаандаа тусган ажиллах;

6.2.10. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшгийн үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх;

6.2.11. Ажилтнуудын нийгмийн хамгааллыг сайжруулах, ажиллах дэмжлэгт орчин бүрдүүлэх;

6.2.12. Хүний нөөцийн мэдлэг ур чадварыг тасралтгүй дээшлүүлж, төрийн албан хаагчийн ёс зүй, хэм хэмжээг мөрдүүлж ажиллах, сахилга, хариуцлагыг сайжруулахад чиглэсэн арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэх;

- 6.2.13. Архив, бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийн зааврыг мөрдөж, цаасан болон цахим архивын санг бүрдүүлэх, тогтмол баяжилт хийх;
- 6.2.14. Хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

Долоо. Захирлын үүрэг

- 7.1. Төвийн Захирал нь хууль тогтоомжид нийцүүлэн тушаал гаргана.
- 7.2. Төвийг бүрэн төлөөлөх бөгөөд үйл ажиллагааны, санхүүгийн, төсвийн гүйцэтгэл, эрүүл мэндийн статистик мэдээ, тайланг тогтоосон хугацаанд нь хүргүүлэх, үнэн зөв байдлыг хариуцна.
- 7.3. Төсвийн ерөнхийлөн захирагчаар жил бүр төвийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн төлөвлөгөөг салбарын урт, дунд, богино хугацааны бодлого, байгууллагын стратеги төлөвлөгөөтэй уялдуулан батлуулж, хэрэгжилтийг зохицуулан тайлагнана.
- 7.4. Төвийн бүтцийн нэгжүүдийн үйл ажиллагааны чиглэл, чиг үүрэг, төлөвлөгөө, байгууллагын дотоод журам, эрсдэлийн удирдлагын болон хуулиар олгогдсон чиг үүргийн хүрээнд бусад дүрэм, журам, албан тушаалын тодорхойлолт батлах, хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх, урамшуулах, сахилгын шийтгэл ногдуулах, хөдөлмөрийн гэрээг цуцлах, хяналт тавина.
- 7.5. Төвийн эрдэм шинжилгээний ажилтны аттестатчиллын удирдамж, комиссын бүрэлдэхүүн, хуваарийг баталж, журмын дагуу аттестатчилал явуулна.
- 7.6. Зэрэг дэвийн шаардлага, шалгуур үзүүлэлтүүдийг хангаж буй эрдэм шинжилгээний ажилтны зэрэг дэвийг ахиулах болон хэвээр хадгалах эсэх талаар аттестатчиллын комиссын үнэлгээ, төвийн Эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн дүгнэлтийг тус тус үндэслэн тушаал гарган баталгаажуулах, Эрдэм шинжилгээний ажилтнуудын зэрэг дэвийн нэмэгдэл олгох төсвийг жил бүрийн төсөвт тусгуулна.
- 7.7. Хэлтэс, алба, нэгжийн дарга болон ажилтнуудыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу томилж, чөлөөлнө.
- 7.8. Удирдах ажилтны ёс зүйг чанд сахиж, авлигаас ангид, үйл ажиллагааны ил тод байдал, жендерийн мэдрэмжтэй байдлыг ханган ажиллана.
- 7.9. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшгийн бэлэн байдлын үед ажиллах байгууллагын тохиолдлын удирдлагын тогтолцоо, гамшгийн шуурхай багийн бүрэлдэхүүн, чиг үүрэг, төлөвлөгөөг тухай бүр тодотгон батлуулж, шаардлагатай тохиолдолд идэвхжүүлэх ажлыг зохион байгуулна.

Найм. Төвийн нэгжийн чиг үүрэг

8.1. Бодлого төлөвлөлтийн хэлтэс

Төвийн алба, нэгжийн үйл ажиллагааны харилцан уялдаа холбоог хангах, төлөвлөгөөний тайлагналт, хэрэгжилтэд хяналт тавих, хүний нөөцийн хөгжил, албан тушаалын тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээний хэрэгжилт, ажилтнуудын нийгмийн хамгаалал, ажиллах орчин, хууль эрх зүй, авлигаас урьдчилан сэргийлэх, төрийн албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлэх, соён гэгээрүүлэх үүргийг хэрэгжүүлнэ.

8.1.1. Стратеги, удирдлагын алба: Төвийн гадаад, дотоод үйл ажиллагаа, хууль, дүрэм, стратеги, журмын хэрэгжилт, өдөр тутмын бэлэн байдлыг хангах, хүний нөөцийн мэргэшсэн тогтвортой байдлыг хадгалж, тасралтгүй мэргэшүүлж чадавхжуулах, архив, номын сан, бичиг хэргийн хөтөлөлт, мэдээллийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг бүрдүүлэх, хэвлэл, статистик мэдээ, мэдээллийг цуглуулж нэгтгэх, дүн шинжилгээ хийх, мэдээний цахим сан бүрдүүлэх, мэдээллийн технологийг хөгжүүлэх, хэвлэлийн цехийн үйл ажиллагааг тус тус хариуцна.

8.1.2. Эрүүл мэндийг дэмжих, мэдээллийн алба: Нийгмийн эрүүл мэнд, эрүүл мэндийг дэмжих чиглэлээр үндэсний хэмжээнд мэргэжил арга зүйгээр хангах, албан бус эрүүл мэндийн боловсрол олгох хэрэгцээг тогтоож, зорилтот бүлгүүдэд эрүүл зан үйл, аж төрөх хэв маягийг төлөвшүүлэх эрүүл мэндийн албан бус сургалтын агуулга, хөтөлбөр, арга зүй, гарын авлагыг боловсронгуй болгоход холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах, зохион байгуулах, эрсдэлт хүчин зүйлс, зан үйлийг судлан тогтоох, хүн амыг халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэг, оношилгоо, шинжилгээнд товллолт хугацаанд хамруулах, үр дүнг тооцож, мэдээллээр хангах ажлыг хариуцна.

8.1.3. Санхүү, аж ахуйн алба: Төвийн санхүү, эдийн засаг, төсвийн бодлогыг тодорхойлж шилэн дансны ил тод байдлыг хариуцах, байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагааг хууль, дүрэм, журмын дагуу явуулах, төсвийн санхүүжилтийг үр ашигтай зарцуулах, өдөр тутмын гүйлгээг хийх, бүртгэх, тайлагнах өмч хөрөнгийн бүрэн бүтэн байдал, ашиглалт, бүртгэлийг хариуцаж, хөрөнгийн зүй зохистой харьцаа, үр өгөөжийг дээшлүүлж ажиллана.

8.2.Эрдэм шинжилгээ, судалгааны хэлтэс

Үндэсний хэмжээнд урьдчилан сэргийлэх анагаах ухааны тусламж үйлчилгээг үзүүлэх, шинжлэх ухааны нотолгоог бүрдүүлэх чадавх бүхий эрдэм шинжилгээний олон талт чадварлаг хүний нөөцийг бэлтгэнэ. Нийгмийн эрүүл мэндийн стратеги, стандарт, эрдэм шинжилгээ, судалгаа, хөтөлбөр, заавар, дүрэм, журам гаргах үндэслэл, нотолгоо, санал, зөвлөмж боловсруулах, сургалт, арга хэмжээг зохион байгуулна.

8.2.1. Орчны эрүүл мэнд, нөлөөллийн үнэлгээний алба: Орчны эрүүл мэндээс хамааралтай хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг үр дагаврыг бууруулах, эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний чиглэлээр нотолгоонд суурилсан санал, заавар, бодлого, стратеги, хөтөлбөр боловсруулах ажил зохион байгуулах, эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ хийх, мэдээллийн сан бүрдүүлэх, лавлагаа зөвлөмжөөр хангах ажлыг хариуцна.

8.2.2. Хоол судлал, хүнсний аюулгүй байдлын алба: Хоол тэжээл, хүнсний аюулгүй байдлын чиглэлээр хамааралтай эмгэгээс сэргийлэх чиглэлээр нотолгоонд суурилсан санал, заавар, бодлого, стратеги, хөтөлбөр боловсруулах, лавлагаа зөвлөмжөөр хангана. Хүнс, хоол үйлдвэрлэлийн байгууллага, аж ахуйн нэгжүүдэд хүнсний аюулгүй байдлын чиглэлээр мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх ажлыг хариуцна.

8.2.3. Шинжлэх ухаан, биоинновацийн алба: Анагаах ухааны биотехнологийн чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг үндэсний түвшинд зохион байгуулах, хийж гүйцэтгэх био аюулгүй байдлын асуудлаар бодлогын санал, зөвлөмж боловсруулах, мэдээ, мэдээллээр хангах ажлыг хариуцна.


8.2.4. Хор судлал, шуурхай удирдлагын алба: Нийгмийн эрүүл мэндийн тандалт, гамшиг, ноцтой байдлын үеийн тархвар зүйн тандалт, болон химийн хордлогын чиглэлээр тогтолцоог өргөжүүлэн хөгжүүлж, шаардлагатай тоон мэдээ, мэдээлэл, хэтийн төлөвийг урьдчилан тооцоолж эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээг төлөвлөн хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих үйл ажиллагааг зохион байгуулах, түгээх ажлыг хариуцна.

8.3.Нийгмийн эрүүл мэндийн үндэсний лавлагаа лаборатори

Хүнс, хоол, хөрс, агаар, ус, биологийн болон бусад дээжинд шинжилгээ хийж, хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөг тогтоох, шинжилгээний аргын стандартыг боловсруулах, батлуулах, лабораторийн үйлчилгээг үндэсний хэмжээнд шаардлагатай тохиолдолд байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүнд үзүүлэх ажлыг хариуцан ажиллана. Тус лаборатори нь биохимийн, хими, хор судлалын, полиомиелитийн, молекул, биологи, вирусологийн, микробиологийн нэгжүүдтэй байна. Үндэсний хэмжээнд нийгмийн эрүүл мэндийн лавлагаа лабораторийн үүргийг гүйцэтгэж, хүн амын дунд гарсан хордлогын шалтгаан, эх үүсвэрийг тодорхойлох, тохиолдлыг баталгаажуулах, лабораторийн тандалт хийх, эрдэм шинжилгээ, судалгаа, үйлдвэрлэлийг хослуулан хөгжүүлэх, ажлыг үндэсний түвшинд зохион байгуулж ажиллана. Олон улсын лавлагаа лабораторийн чанарын хяналтад хамрагдаж, сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхид тавих ерөнхий шаардлага (MNS ISO/IEC 17025:2018)-ыг ханган ажиллана.

8.4.Биобэлдмэлийн үйлдвэр

Биотехнологи, биоинформатик, хүний генетикийн чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгаа, үйлдвэрлэлийг хослуулан хөгжүүлэх, чанар, аюулгүй байдлыг хангасан вакцин, биобэлдмэл үйлдвэрлэх, бүртгүүлэх, нийлүүлэх, түгээх ажлыг үндэсний түвшинд зохион байгуулна. Тус үйлдвэр нь уургийн бэлдмэлийн, вакцин оношлуурын, чанарын хяналтын нэгжүүдтэй байна. Биоаюулгүй ажиллагааны заавар, аргачлалыг боловсруулан, мөрдөж ажиллана.



Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн зохион байгуулалтын бүтэц

